

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА

Б.Санжмятав¹

Өгүүллийн товч: *Монгол Улсын олон улсын худалдааны тэнцэл нь ДНБ-тэй үндсэндээ тэнцэж, монголын эдийн засаг олон улсын худалдаанаас бүхэлдээ хамаардаг болсон байгаа боловч худалдааны хуульгүй, худалдааны яамгүй, худалдааны бодлогын баримт бичиггүй явж байна. Энэ байдлыг 2014 онд ДХБ-д Монгол Улсын худалдааны илтгэлийг хэлэлцэхэд НБДНГ-ын илтгэлд дурдсан, мөн Худалдааны бодлогыг хянах хорооны хурлын үеэр гишүүн орнуудаас сануулсан байгаа. Энэ нөхцөл байдалд дүгнэлт хийж, түүнийг нааштайгаар өөрчлөх талаар энэ өгүүлэлд өгүүлж байна.*

Түлхүүр үг: *Монгол Улсын худалдааны бодлого, худалдааны бодлогыг хянах,*

Key words: *International trade policy of Mongolia, trade policy review*

Монгол Улсын худалдааны бодлого, тулгамдаж буй асуудлууд

Монгол Улсын гадаад худалдааны эргэлт үндсэндээ ДНБ-тэй тэнцэж, 1990 оноос хойш хүлээн авсан Гадаадын шууд хөрөнгө оруулалт ДНБ-ээс аль хэдийн давсан, худалдааны тэнцэл олон жил их алдагдалтай явж ирсэн нь худалдааны бодлого улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд чухал үүрэгтэй болохыг харуулна.

Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад 1997 онд элсэн орж, олон улсын худалдааг ДХБ-ын хүрээнд тогтоосон олон талт худалдааны эрх зүйн орчинд хийх болсон. Тийм учраас Монголд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь гадаад зах зээл дээр Үндэстний нэн тааламжтай байх зарчмын үндсэн дээр таатай орчинд борлуулагдах, өрсөлдөх эрхтэй болсон. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Засгийн газар бусад орны импортын бараа бүтээгдэхүүний

1. Олон улсын эдийн засгийн ухааны доктор (Ph.D)

хувьд ихээхэн либераль бодлого баримталж ирсэн. Монгол Улс ДХБ-д элсэхдээ хоёр талын хэлэлцээг маш муу хийж, үүрэг авсан тарифын хэмжээг дунджаар 17,5%-иар тогтоосноос гадна одоо 5%-ийн тарифыг хэрэглэж байгаа нь дэлхийн дунджаас нэлээд доогуур байна.

Монгол Улс экспортод уул уурхайн гаралтай боловсруулаагүй түүхий эд гаргаж байгаа нь гадаад зах зээл дээр татваргүй шахам гардаг, Монгол Улс маш доогуур тарифтай тул манай хувьд худалдааны асуудлууд гардаггүй. Гэвч энэ байдал нь улс орны дотоодын эдийн засаг, зах зээл, үйлдвэрлэлийн түвшинд сайн нөлөө үзүүлэхгүй, харин ч хохиролтой байдаг болно.

Ингээд Монголын гадаад худалдааны байдал, худалдааны бодлого, түүнд тохиолдож буй тулгамдсан асуудлуудыг салбараар нь авч үзье:

Нэг. Монголын гадаад худалдааны байдал, хандлага

Монгол Улсын олон улсын худалдааны эргэлт 2014 онд 11,01 тэрбум ам. доллар , үүнээс экспорт 5 774 569.3 мянган ам. доллар, импорт 5 236 636.0 мянган ам. доллар байжээ. Монгол, Улсын гадаад худалдааны тэнцэл 2014 онд сүүлийн олон жилийн туршид анх удаа ашигтай гарсан ба хамгийн их ашиг БНХАУ-тай хийх худалдаанаас 3 305 сая ам. долларын ашигтай гарчээ.


МУ-аас гадаад орнуудтай хийж байгаа худалдааны дийлэх хэсэг нь хөрш орнуудтай байна. 2014 оны байдлаар Монголын нийт экспортын 89% нь, импортын 63% нь хөрш орнуудтай хийгджээ²:

2. Үндэсний статистикийн хороо, МУ-ын нийгэм, эдийн засгийн байдал, 2014.12 сар, х 72

Зураг 1

Монголын экспортод хөрш орнуудын
эзлэх жин, 2014³

Импортод хөрш орнуудын
эзлэх жин, 2014



Монгол Улсын экспортод газрын баялаг болох түүхий эд, импортод түлш, шатахуун, хүнсний зүйлс, барилгын материал, машин, техник, тоног төхөөрөмж голлож байна.

Хүснэгт 1

Монголоос гадаад зах зээлд нийлүүлж байгаа үндсэн бараа⁴, сая ам. доллараар

Экспорт	Цайрын хүдэр, баяжмал			Зэсийн баяжмал			Төмрийн хүдэр		
	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014
Нийт	130,8	119,0	113,1	838,6	948,9	2 573,6	532,5	654,3	446,7
Үүнээс Хятадад	130,8	119,0	113,1	838,6	948,9	2 560,7	532,5	654,3	446,3

3. Үндэсний статистикийн хороо, МУ-ын нийгэм, эдийн засгийн байдал, 2014.12 сар, х 72

4. мөн тэнд

Экспорт	Чулуун нүүрс			Молибдений хүдэр, баяжмал			Жоншны хүдэр, баяжмал		
	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014
Нийт	1 880,4	1 116,1	848,6	38,1	29,4	35,6	102,5	83,2	71,5
Үүнээс Хятадад	1 874,9	1 116,1	847,1	30,7	17,7	36,6	37,6	41,8	32,5

Хоёр. Монгол Улсын худалдааны бодлого

Монгол Улс сүүлийн олон жилийн турш хөгжлийн бодлогогүй, түүний дотор худалдааны бодлогогүй явж ирлээ. Үүнийг олон баримтаар нотолж болно. Хэдийгээр худалдаа нь Монгол Улсын эдийн засагт, түүний хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй байгаа боловч манай улс худалдааны яамгүй, худалдааны хуульгүй, бүр зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогогүй, төрийн бүтэцгүй шахам явж ирсэн байна.

Монгол Улс эдийн засгаа зах зээлийн харилцаанд шилжүүлж, чармайлт гаргаж байгаа боловч энэ нь ямар ч зохицуулалтгүй, урсгалаараа явна гэсэн үг биш юм. Өнөөдөр дэлхийн бүх улсууд дотроос Монгол Улс ганцаараа зах зээлийн эдийн засгийн үзэл баримтлалыг ярьсаар явахад, дэлхийн бусад бүх орон төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжээд байна. Хамгийн сүүлд уламжлалт зах зээлийг эрхэмлэдэг байсан АНУ зэрэг орнууд 2008 оны дэлхийн мөнгө санхүүгийн хямралын дараагаас мөн л төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн. Энэ нь Монгол Улсын зүгээс урт хугацаанд хөгжлийн стратегиа нийтийн жишгээр тодорхойлж, хөгжлийнхөө зорилгод нийцсэн салбарын, түүний дотор худалдааны бодлогоо тодорхойлон явуулах цаг болсныг бэлхнээ харуулж байна.

Монгол Улс хөгжлийн стратегигүй, худалдааны бодлогогүй явж байгааг гадаадын нэр хүнд бүхий олон улсын институтцээс ч анхааруулж байгаа болно. Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааны бодлогыг хянах хорооны 2014 оны 9 дүгээр сарын 23-26-нд болсон хуралдаанаар Монгол Улсын худалдааны илтгэлийг авч хэлэлцэхэд, ДХБ-ын НБДНГ-аас боловсруулсан илтгэл, гишүүн орнуудын зүгээс манай Засгийн газарт тодорхой зөвлөмжүүдийг өгсөн. Тухайлбал, НБДНГ-аас Монгол Улсын худалдааны бодлогын талаар боловсруулсан илтгэлийн зарим үндсэн хэсгээс авч үзвэл⁵:

Илтгэлийн 1-дМонгол Улсын өнөөгийн анхаарах ёстой нэг томоохон асуудал бол ГШХО-ыг хяналтандаа байлгах, экспорт, түүнээс орох орлогыг зөв удирдах явдал болж байна.

2....Уул уурхайн бүтээгдэхүүн нь экспортын орлогын 84%-ийг бүрдүүлж, экспорт нь үндсэндээ бүтнээрээ Хятадад гарч байгаад анхаарах хэрэгтэй болжээ.

3. ...Засгийн газраас эдийн засгаа хөгжүүлэхдээ уул уурхайгаас гадна бусад салбаруудыг хөгжүүлэхэд анхаарч байгааг цаашид ч үргэлжлүүлэх хэрэгтэй.

7. Монгол Улс ДХБ-д 1997 онд элсэхдээ тарифын үүснэгт авсан амлалтын хэмжээ(bound tariff)-г ойролцоогоор 20% байхаар тохиролцсон боловч одоо 5%-ийн тариф (applied tariff)-ыг хэрэглэж, 60 гаруй бүтээгдэхүүний хувьд/тухайлбал этилийн спиртийн хувьд илүү, үржлийн мал/ амлалтаа давсан тариф баримталж байна.

8.Монгол Улсад одоогоор 600 гаруй стандарт, техникийн нормыг мөрдүүлж байгаа боловч түүний хагас нь олон улсын нормд нийцэхгүй байна.

2.16 Монгол ямар нэгэн гишүүнтэй худалдааны маргаан үүсгээгүй.

3.31Монгол Улсад анти демпингийн арга хэмжээг хариуцсан байгууллага төрийн албанд нь байхгүй, анти демпингийн эсрэг арга хэмжээ авч байгаагүй.

3.32 Монгол Улс нөхөн төлбөрийн арга хэмжээ авч байгаагүй.

3.33 Монголын хуулинд хамгаалалтын арга хэмжээ авч болох

5. TPRB: Secretariat Report on trade policy of Mongolia, 2014, www.wto.org

талаар ямар нэгэн заалт байхгүй, тийм төрлийн арга хэмжээг 2005 оноос хойш авч байгаагүй.

Ийнхүү ДХБ-ын НБДНГ-ын илтгэлд Монгол Улсын эдийн засаг нь нэлээд өрөөсгөл, буруу замаар хөгжиж, төрийн зүгээс хяналтаа тавьж, чиглүүлж чадахгүй байгааг хэлснээс гадна үндэсний зах зээлээ, үйлдвэрлэлээ хамгаалах бодлогогүй, мөн энэ асуудлыг хариуцах төрийн бүтцийн байгууллага ч байхгүй байгааг анхааруулжээ. Мөн Монгол Улсын худалдааны илтгэлийг хэлэлцсэн хуралдааны үеэр ДХБ-ын 40 гаруй гишүүн орны төлөөлөгчөөс үг хэлж, Монголын Засгийн газарт зөвлөгөө өгсөн байна.Тэдгээрээс илүү анхаарал татсан зарим орны төлөөлөгчийн хэлсэн үгээс танилцуулбал⁶:

Колумбийн төлөөлөгчөөс:

- Үүрэг амлалт давсан 60 орчим барааны тарифыг амлалтын хэмжээний түвгинд буюу түүнээс доогуур авчрах,
- ЧХХ нь дэлхийн эдийн засагт интеграцчилагдах, илүү ашигтай нөхцлөөр худалдаа хийх нөхцлийг бүрдүүлдэг,
- Үндэсний зах зээлээ хамгаалах, үйлдвэрлэлээ дэмжих асуудлыг төрийн бүтцийн байгууллагад хамааруулж, хариуцуулах,
- Эдийн засгийг цөөн салбараас хамаарч байгааг өөрчилж, илүү өрсөлдөх чадвартай, солонгорсон эдийн засгийг бодлогоор хөгжүүлэх,

АНУ-ын төлөөлөгчөөс:

- Монголд шийдвэр гаргах үйл явц ямагт урьдчилан харах боломжгүй байгааг өөрчилж, илүү ил тод, тогтвортой болгох,
- Хууль гарсан байлаа ч Засгийн газар, эрх барих байгууллагууд хуулийн хэрэгжилтийг дур мэдэн хойшлээлж байдгийг болиулах,

Тайвань (Хятад)-ийн төлөөлөгчөөс:

- Худалдааны болон төлбөрийн тэнцлийг хангах бодлого явуулах,

Бразилийн төлөөлөгчөөс:

- Үндэсний стандартуудыг олон улсын стандартад нийцүүлэх ажлыг даруй хийж гүйцэтгэх,

6. TPRB, Minutes of meeting, 24 and 26 September 2014, www.wto.org

Японы төлөөлөгчөөс:

- Монголд газрыг гадаадын иргэн, компанид өмчлүүлэхгүй байгаа, бизнесийн орчны шийдвэр гаргах үйл явц ил тод биш байгааг өөрчлөх,
- Зарим онцгой татварын хэмжээ үүрэг авсан хэмжээнээс илүү гарсан байгааг бууруулах,
- ГШХО-ыг татахын тулд дэд бүтцийг сайжруулах, ДХБ-ын хүрээнд авсан үүргийнхээ дагуу олон талт худалдааны хэлэлцээрийн биелэлтийг НБДНГ-т өгөх ажлыг сайжруулах

Хуралдааны төгсгөлд ДХБ-ын Худалдааны бодлогын хорооны хуралдааныг даргалагчаас дараах зүйлийг зөвлөсөн байна⁷:

Монголын эдийн засаг суурь муутай байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлж, цөөн бүтээгдэхүүнээс хамаарч байна гэж үзэх үндэстэй байна. Энэ байдлыг засах нь амаргүй, тийм учраас сайн бодлого хэрэгтэй. Монгол Улс ЧХХ байгуулаагүй, бүс нутгийн интеграцчилалд оролцоогүй байгаа нь байдлыг улам хүнд болгож байна. Олон төлөөлөгчийн хэлснээр, Монгол нь дэд бүтцэд холбогдоогүй байгаа нь байдлыг амаргүй болгож байна. Гэвч Засгийн газраас авто, төмөр замын талаар томоохон төлөвлөгөө гаргаж байгаа нь хэрэгжих байх гэж найдаж байна. Тэгээд Монголын Засгийн газар дараах чиглэлээр анхаарч, ахиц гаргах байх гэж хүлээж байна⁸. Үүнд:

- **Хөрөнгө оруулалтын салбарт:** 2013 оны хөрөнгө оруулалтын хууль нь ГШХО-ыг бүртгэх, үйл ажиллагааг нь явуулахад таатай нөлөө үзүүлнэ гэж найдаж байгаа боловч хуулийг хэрэгжүүлэх, шинэ хууль гаргахдаа нөхцлийг бууруулахгүй байх. Тухайлбал, ГШХО-ыг бүртгэхэд шаардлагатай гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгийн доод хэмжээний шаардлага, мөн хөрөнгө оруулалтын татвар, зардлын нөхцлийг тогтворжуулах нөхцөл нь хэтэрхий цөөн байгаад анхаарах,
- **Засгийн газрын худалдан авалт, дэд бүтцийн хөрөнгө оруулалт:** Дэд бүтцийн салбарт, юуны өмнө авто зам, төмөр

7. ДХБ-ын ХБХХ-ны хуралдаанаас илтгэлээ хэлэлцүүлсэн орны Засгийн газарт өгөх зөвлөмжийг хурал даргалагчийн үгийн хэлбэрээр гаргадаг уламжлалтай.

8. TPRB, Minutes of meeting, 24 and 26 September 2014, www.wto.org

зам, цахилгаан эрчим хүчний салбарт сонгон шалгаруулалт явуулахдаа ил тод байх явдал хангалтгүй байгааг нэлээд хэдэн орны төлөөлөгч сануулж байгаад анхаарах,

- **Түүхий эдийн олборлолтын салбарт:** Хөрөнгө оруулалтын шинэ хууль гарсан боловч түүнийг хэрэгжүүлэх, шинээр лиценз олгох ажил удааширч байгаад анхаарах,
- **Зарим тарифын хэмжээ үүрэг амлалтаас өндөр байгааг зохицуулах:** Ерөнхийдөө Монгол Улсад хэрэглэж буй тариф нь үүрэг амлалтын түвшингээс нэлээд доогуур байгаа боловч зарим онцгой татварын хэмжээ үүрэг амлалтын хэмжээнээс өндөр байгаа, мөн зарим бүтээгдэхүүний импортын тариф нь дотоодын бүтээгдэхүүнд ногдуулдаг татвараас өндөр байгааг бууруулах,
- **Стандартын салбарт:** Монголын дотоодын олон стандарт нь олон улсын түвшний стандартаас, тухайлбал эрүүл мэнд, эрүүл ахуйн шаардлагаас хоцорч байгааг арилгах,
- **Захиргааны бүтцийн асуудлууд:** Олон орны төлөөлөгчөөс хэлсэн үгэндээ, Монголд импортын лиценз авах, гадаадын хөрөнгө оруулалтыг бүртгүүлэх, бүр техникийн туслалцаа үзүүлэхэд ч хүн сурталтай байж, цаг их авдаг тухай ярилаа. Биеэ даасан улс орон бүр дотоодын асуудлаа өөрсдөө шийдвэрлэх эрхтэй боловч захиргааны бэтцийн хүнд суртлыг бууруулах, чадавхийг нь сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлага байгаа нь харагдаж байна.

Эцэст нь, Монгол нь худалдаа, хөрөнгө оруулалтынхаа орчныг сайжруулах талаар ихээхэн ахиц гаргаж байгаа боловч, цаашид төрийн байгуулалтынхаа ил тод байдлыг сайжруулах, үр ашгийг нь дээшлүүлэх, хээл хахиултай тэмцэх шаардлага байна гэж дүгнэж хэлжээ.

Гурав. Худалдааны таатай орчин бүрдүүлэх

Дэлхийн худалдаа, эдийн засаг даяаршиж, зах зээлүүд харьцангуй чөлөөтэй, бас татвар багатай болж байгаа боловч худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хамгийн таатай нөхцөл **бүс нутгийн интеграцчиллын хүрээнд, чөлөөт худалдааны бүсүүдэд** юуны өмнө хэрэгжиж байгаа.

ДХБ нь олон улсын хэмжээнд худалдааны нэгдсэн тогтолцоог бий болгох зорилготой боловч бүс нутгуудын интеграцчилал, чөлөөт худалдааг зарчмын хувьд дэмжиж ажилладаг. Учир нь бүс нутгуудад үүссэн таатай нөхцлүүд нь даяаршиж, олон улсын худалдаанд нааштай нөлөө үзүүлнэ гэж үздэгтэй холбоотой байна.

Улс орнууд бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллахад дуртай байдгийн үндэслэл гэвэл, зах зээл, хүн амын соёл, амьдралын түвшин ойролцоо байх тул бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэмэлт шаардлага бага тавьдаг, тээврийн зардал хямд, харилцан худалдаа хийхэд хялбар байдаг зэрэгтэй холбоотой. Сүүлийн жилүүдэд улс орнууд ЧХХ-ийг олноор байгуулж байгаа нь ялангуяа жижиг орнууд зах зээлээ тэлж, ГШХО-ыг татах, өрсөлдөх чадвараа сайжруулах хүсэлтэй холбоотой байна. 2015 оны 1 дүгээр сарын 15-ны байдлаар ДХБ-д нийт 604 бүс нутгийн интеграчиллын хэлэлцээр байгуулагдсан байгаагийн 398 нь хүчин төгөлдөр болсон байна. Нийт хэлэлцээрийн 90% нь ЧХХ, үлдсэн хэсэг нь гаалийн холбоо, эдийн засгийн холбооны хэлэлцээр байна⁹.

Монгол Улс 2014 онд Японтой ЧХХ-ийн ариа боловсронгуй, илүү өргөн хүрээтэй хэлбэр болох Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулсан. Хэлэлцээрийг Монголын Улсын Их Хурал, Японы парламент баталсан, удахгүй хэрэгжиж эхэлнэ. Уг хэлэлцээрийн хүрээнд талууд өөр хоорондын худалдаанд бараа, үйлчилгээний тарифын 90 шахам хувийг бууруулах, тарифаас чөлөөлөх талаар үүрэг авснаас гадна хөрөнгө оруулалтыг дэмжих, эдийн засгийн хамтын ажиллагааг, түүний дотор ажиллах хүчний салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх зарим таатай нөхцлийг бүрдүүлж өгсөн. Манай бизнесийн хүмүүс овсгоотой ажиллаж чадвал бас ч нэлээд шинэ бололцоог нээсэн болно.

Аливаа ЧХХ-ийн гол зорилго бол түүнийг байгуулж буй орнуудын зүгээс зах зээлээ тэлэх, өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү том зах зээлд борлуулах боломжтой байх, бас өөрт хэрэгтэй бүтээгдэхүүнийг хямд үнээр олж авах, ГШХО-ыг зорилготой байдаг. Гэвч Монгол, Японы ЭЗТХ нь Монголын хувьд дээрх зорилгод бага нийцэж байгаа бөгөөд эл хэлэлцээрийг байгуулах нь эхнээсээ улс төрийн зорилготой байсан болох нь ажиглагддаг.

9. Regional trade agreements, 2015, www.wto.org

Монгол Улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь Японд борлогдох боломж тун бага байх бөгөөд монголын зах зээлийг тэлж чадахгүй юм. Үүнийг одоогийн худалдааны сүүлийн 3 жилийн түвшин ч харуулж байна¹⁰:

	2012		2013		2014	
	Мянган \$	%	Мянган \$	%	Мянган \$	%
Экспорт	5 602.6	0.1	10 534.3	0,2	24 451.2	0,4
Импорт	501 618.2	7.4	444 201.8	7.0	367 789.5	7.0

Эрдэмтдийн судалгаанаас үзвэл, Монгол Улс гадаад орнуудтай ЧХХ байгуулахад эдийн засгийн макро түвшинд бага нөлөө гарах боловч, ОХУ, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд орж байсан орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах нь зах зээлийг тэлэхээр байна¹¹. Энэ байдал Казахстанд ч ийм байсан тухай судалгаа байна. Казахстан 17,5 сая хүн амтай болох нь төдийлөн сайн зах зээл байсан ба энд ГШХО харьцангуй бага ирж байсан ажээ. Гэтэл Казахстаныг Евразийн гаалийн холбоонд нэгдэсний дараагаас зах зээл тэлэгдэн 200 сая хүн болох үеэс энэ зах зээлийн хэрэгцээг хангах зорилготой ГШХО Казахстанд эрс нэмэгдсэн байна¹².

Стратегийн ач холбогдолтой түүхий эд, бүтээгдэхүүнээр үндэсний үйлдвэрлэлийг хангах нь өнөөдөр дэлхийн нийт улсуудын зорилт болж байна. Монгол Улс өнөөдөр хэрэглэж буй түлш шатахуунаа бүхлээр нь ОХУ-аас, хүнсний бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг Хятадаас авч байгаа бөгөөд нийлүүлэгчийг олон болгох нөхцөл, бололцоо муу байна. Гэтэл монголчуудын амьдрал дээрх бүтээгдэхүүний хамгамжаас шууд хамаарч байгаа тул хамаарлыг багасгаж, боломжийн хирээр өөртөө үйлдвэрлэдэг болох нь үндэсний аюулгүй байдалд нийцэж байна. Мөн гадаад зах зээл дээр дээрх бүтээгдэхүүний олоц нь муудаж, зарим тохиолдолд мөнгө байлаа ч хэрэгцээт бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлээс худалдан авах бололцоогүй болох нөхцөл үүсэх төлөвтэй. Тухайлбал, нефтийн

10. УСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2014.12, х 72

11. Ш.Энхбаяр, Т.Накаэжима, ЗХА-ийн орнуудтай ЧХХ байгуулснаар МУ-ын эдийн засагт гарах нөлөөллийн шинжилгээ, The Northeast Asian Economic Review, 2013, n 2-1

12. Нйline ROUSSELOT, Le Kazakhstan et l'Union eurasiatique : quels sont les enjeux de l'adhésion ? mardi 13 janvier 2015, www.diploweb.com

бүтээгдэхүүний нөөц дэлхийн хэмжээнд 40 жилийн хэрэгцээг хангахаар байгаагаас гадна 2035 он гэхэд нефтийн нөөцгүй, түлш шатахуун үйлдвэрлэдэггүй бол түлш шатахуун олж авч чадахгүй нөхцөл үүсч болох тухай судалгаанууд байна. Хүнсний хувьд гэвэл, хүн төрөлхтөн одоо дараа жилийн ургац хүртэл нөөц бүрдүүлж чадахгүй болсон ба дэлхийн хэмжээнд хүнсний нөөцийн хэмжээ жилээс жилд буурах болсон. Хүн төрөлхөтний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахын тулд 2050 он гэхэд бидэнд 2 дэлхий хэрэгтэй болох тухай ч судлаачид бичиж байна¹³.

ДХБ-ын олон талт худалдааны эрх зүйн орчинд үндэсний эрх ашгаа хамгаалах асуудал бол Монголын худалдааны бодлогын нэгээхэн чухал зорилт болно. 2014 онд Монголын худалдааны бодлогын илтгэлийг ДХБ-д хэлэлцэхэд, Монгол Улс үндэсний зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих бодлогогүй, бас эдгээр асуудлыг хариуцдаг төрийн бүтцийн байгууллага ч байхгүй байгаа талаар ярьж, зөвлөгөө өгсөн байгаа.

Монгол Улсын нэгдэн орсон ДХБ-ын олон талт худалдааны эрх зүйн орчин нь нэлээд хагуу боловч гишүүн орнуудад үндэсний эрх ашгаа хамгаалах өргөн бололцоог олгодог, бас тусалдаг. Монгол Улс ДХБ-д элсэхдээ тарифын үүрэг авсан хэмжээг дунджаар 17,5% байхаар тохирсон боловч одоо 5%-ийн нэгдсэн тарифыг хэрэглэж байгаа нь үндэсний эрх ашигт нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, үндэсний зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зорилгоор одоо хэрэглэж байгаа 5%-ийн тарифыг дунджаар 17,5% болгон өсгөх эрх нь Засгийн газарт байгаа. Гэвч Засгийн газар хангалтгүй ажиллаж ирсэн байна. Харин одоо Шийдлийн Засгийн газраас үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлогыг боловсруулж, тарифынхаа хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа нь зүйтэй байна.

Засгийн газраас үндэсний эрх ашгаа хамгаалахад олон талт худалдааны эрх зүйн орчинд тарифаас гадна олон төрлийн бололцоо байна. ДХБ-ын хүрээнд боловсруулан баталсан олон талт хэлэлцээрүүдэд, тухайлбал ХАА-н бүтээгдэхүүний худалдааны тухай хэлэлцээр, Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай

13. Б.Санжмятав, Дэлхийн эдийн засаг, УБ, 2015, х 243-312

хэлэлцээр, Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээр, Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр, Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрүүдэд үндэсний эрх ашгаа хамгаалах арга хэмжээ авах өргөн бололцоог олгосон байдаг.

Гэтэл Монгол Улсын Засгийн газраас эдгээр бололцоог ДХБ-д 1997 онд элсэнээс хойшхи 20 шахам жилийн хугацаанд нэг ч удаа ашиглаагүй, бас эдгээр асуудлыг төрийн байгууллагын бүтцэд албан ёсоор хариуцуулаагүй, үндэсний эрх ашгаа хамгаалах зорилгоор ямар нэгэн улстай маргаан үүсгээгүй явж ирсэн байна.

Худалдааны олон талт тогтолцооны эрх зүйн орчны зарим боломжоос тодруулбал:

Худалдааг чөлөөтэй болгосноос шалтгаалан өсөн нэмэгдсэн импорт нь дотоодын үйлдвэрлэл, зах зээлд сөргөөр нөлөөлөх үед хамгаалалтын яаралтай арга хэмжээ авахыг ТХЕХ-ийн 19, Татаас болон Саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр, ХАА-н тухай хэлэлцээрийн 5 дугаар зүйлд зөвшөөрсөн.

Татаасын тухай хэлэлцээрийн хүрээнд хүнсний аюулгүй байдлыг хангах, эрдэм шинжилгээний эрэл хайгуулын ажил хийх, зарим тохиолдолд экспортын бүтээгдэхүүнийг дотооддоо тээвэрлэхэд татаас олгох бололцоо байгаа.

Саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн хүрээнд импортын бүтээгдэхүүн нь дотоодын зах зээлд, мөн үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөхөөр орж ирж байгаа тохиолдолд саармагжуулах татварыг тогтоож, асуудлыг судлах, нөгөө талтай хэлэлцээнд орох, шаардлагатай тохиолдолд саармагжуулах тарифыг хэсэг хугацаанд мөрдүүлэхийг зөвшөөрдөг.

Дотоодын зах зээлд импортын бүтээгдэхүүн хэт доогуур үнээр орж ирж, үйлдвэрлэл, зах зээлд нөлөөлж байгаа тохиолдолд демпингийн эсрэг арга хэмжээ авч болно. Демпингийн эсрэг татвар нь демпингийн ялгавартай тэнцүү буюу түүнээс доогуур, тэгэхдээ тэрхүү доогуур түвшин нь дотоодын аж үйлдвэрт учирч буй хохирлыг арилгахуйц байх ёстой.

Хамгаалалтын арга хэмжээг импортын бүтээгдэхүүн нь үндэсний үйлдвэрлэлд аюул учруулахаар, эсхүл дөнгөж бий болсон үндэсний

үйлдвэрлэлийг дэмжиж хөл дээр нь зогсох хүртэлх хугацаанд түр хугацаагаар авч хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг.

Хүн амын эрүүл мэнд, амьтан ургамлын эрүүл ахуйн шаардлагын хүрээнд улс орнууд шаардлагатай үед холбогдох арга хэмжээг шууд авч, хатуу хэрэгжүүлэх, хангалттай үндэслэл байгаа нөхцөлд аюулт өвчин тархахаас сэргийлэн урьдчилсан арга хэмжээ авах бололцоог олгодог. Хэлэлцээр мөн шинжлэх ухааны нотолгоо хангалттай биш байлаа ч, тодорхой хугацаанд урьдчилан сэргийлэх үүднээс эрүүл ахуйн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг.

Стандартын шаардлага нь тариф, тооны хязгаарлалт зэргээс үндсээрээ ялгаатай бөгөөд бүтээгдэхүүний өөрийнх нь шинж чанартай холбоотой боловч эцсийн хэрэглэгчийн хэрэглээнд нийцсэн байхыг шаарддаг болно. Тийм зохицуулах ажиллагааны эцсийн зорилго бол үндэсний зах зээл, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад оршино.

Дэлхийн газрын баялаг хомсдож, дуусах тийшээ явж байгаа тул түүнийг ариг гамтай хэрэглэх, илүү зохистой зарцуулах, зарим хэсгийг нь хойч үедээ үлдээх, боловсруулалтын түвшинг ахиулж экспортлохын тулд экспортын татварыг тогтоож, бүр жилд экспортлох бүтээгдэхүүний дээд хязгаарыг тогтоож байна. Худалдааны олон талт тогтолцоонд экспортын тарифын дээд хэмжээг тогтоосон хязгаарлалт байхгүй.

Ийнхүү олон улсын худалдаа, эдийн засгийн гадаад хамтын ажиллагааны үр өгөөжийг сайжруулах, худалдааны олон талт тогтолцооны хүрээнд олгогдсон бололцоог ашиглах өргөн боломж байгаа нь харагдаж байна.

Судалгаандаа үндэслэн дараах арга хэмжээг ойрын үед авч хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

1. Монгол Улсын худалдааны хууль, худалдааны бодлогыг даруй баталж, төр засгийн эрх үүргийн хуваарийг тодорхой болгох, ингэхдээ ДХБ-аар МУ-ын худалдааны илтгэлийг хэлэлцэхэд ХБХХ, гишүүн орнуудаас өгсөн зөвлөмжийг харгалзан үзэх,

2. Худалдаанаас эдийн засагт үзүүлэх нөлөөг харгалзан үзэж, Худалдааны яам байгуулах, Үндэсний үйлдвэрлэгчид, дотоодын зах зээлийг хамгаалах ажлыг төрийн бодлогын хүрээнд авч үздэг болох,
3. Дотооддоо үйлдвэрлэж чадах бүтээгдэхүүний импортын тарифыг даруй нэмэгдүүлэх, демпингийн эсрэг, хамгаалалтын, саармагжуулах зэрэг арга хэмжээг авдаг тогтолцоог бий болгох,
4. Газрын баялгийг түүхий эдээр нь гаргах явдлыг багасгах, боловсруулалтын түвшинг ахиулж бүтээгдэхүүнд илүү өртөг шингээх зорилгоор экспортын тарифыг тогтоож мөрдүүлэх,
5. Дэлхий дээр нэн ховордож буй зарим металл, газрын ховор элемент зэргийг ашиглах төрийн бодлогыг боловсруулан батлах, зарим тохиолдолд эцсийн бүтээгдэхүүн гаргах чиглэл гаргах,
6. Бүс нутгийн интеграцчилалд нэгдэн орох, бүс нутгийн дэд бүтцэд холбогдох, Евразийн холбоотой ЧХХ байгуулах чиглэлээр ажиллах,
7. Экспортын бүтээгдэхүүнийг борлуулахад “нэг цонх”-ны бодлогыг хэрэгжүүлэх,
8. Дээд зэрэглэлийг бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, мөн архи, тамхийг импортлоход татварыг нэмэгдүүлэх,
9. Худалдааг хөгжүүлэхэд “эдийн засгийн чөлөөт бүс”, “чөлөөт худалдааны бүс”-ийг өргөн ашиглах, урд, хойд хил дээр хоёр улсын хил дамнасан чөлөөт худалдааны бүс хамтран байгуулах, -эдгээр болно.

АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛ

- МУ-ын нийгэм, эдийн засгийн байдал, Үндэсний статистикийн хороо, 2014.12 сар
- WTO TPRB: Secretariat Report on trade policy of Mongolia, 2014,
- WTO TPRB: Government Report on trade policy of Mongolia, 2014,
- WTO TPRB, Minutes of meeting, 24 and 26 September 2014,

- Олон талт худалдааны хэлэлцээний Уругвай үе шатны дүнд байгуулсан эрх зүйн баримт бичгүүд, Улаанбаатар, 2000,
- guide to GATT law and Practice, Geneva, 1994
- ДХБ дахь Монгол Улс, Улаанбаатар, 2003
- Sanitary and Phytosanitary measures in WTO law, Brussels, 2001
- ДХБ:олон улсын худалдаа, эдийн засгийн харилцааны эрх зүйн үндэс болох нь, ГЕГ-ын дэргэдэх Гааль, эдийн засгийн сургууль, УБ, 2010
- Д.Авирмэд, Олон улсын худалдаа ба эдийн засаг, УБ, 2012
- Ш.Энхбаяр, Т.Накаэжима, ЗХА-ийн орнуудтай ЧХХ байгуулснаар МУ-ын эдийн засагт гарах нөлөөллийн шинжилгээ, The Northest Asian Economic Review, 2013, n 2-1
- Нйline ROUSSELOT, Le Kazakhstan et l'Union eurasiatique : quels sont les enjeux de l'adhйsion ? mardi 13 janvier 2015, www.diploweb.com
- Бизнес эрхлэгчдэд зориулсан гарын авлага:Гадаад худалдааны бичиг баримт, МҮХАҮТ, УБ, 2007
- Б.Санжмятав,Монгол Улсын эдийн засгийн гадаад хамтын ажиллагааны бодлогын тулгамдсан асуудлууд, Улаанбаатар, 2012
- Б.Санжмятав, Олон улсын худалдаа, УБ, 2013, 2015
- Б.Санжмятав, Дэлхийн эдийн засаг, УБ, 2014, 2015
- Вэб:
- www.wto.org
- www.unctad.org
- www.intracen.org